



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/597

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2, 7 дугаар зүйлийн 7.1, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, 17.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих” нэрлэсэн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн боловсрол, хөгжлийг дэмжсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хүүхдийн “Уран дөш” зуслангийн үйл ажиллагааг дэмжих, Ерөнхий боловсролын сургуулийн зарим дотуур байруудад “Итгэлтэй утас” байршуулах, VR технологийн үйлчилгээг сум, сургуулиудад нэвтрүүлэх, сургуулийн “Хүүхдийн сэтгэл зүйн өрөө”-г стандартын дагуу тохижуулахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн боловсрол, хөгжлийг дэмжсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээнд зарцуулах зардал 38,000,000 (гучин найман сая) төгрөгийг “Гэр бүлийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангаж, биелэлт үр дүнг тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа), аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Ч.Дашбаяр) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны 11.
дүгээр сарын 05-ны өдрийн 153р
захирамжийн хавсралт



**“ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ” НЭРЛЭСЭН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ
ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ**

№	Арга хэмжээний хүрээнд гарах зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Итгэлтэй утас”-ыг дотуур байруудад байршуулах.	5 дотуур байранд 5 утас	984,500	4,922,500
2	ЕБС-иудад “Сэтгэл зүйн өрөө”-г тохижуулах.	2 сургуульд 2 өрөө	7,976,250	15,952,500
3	“Уран дөш” зусланг түшиглэж бүсийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.	1 зуслан	10,800,000	10,800,000
4	VR технологийн үйлчилгээг сум, сургуулийн хүүхэд хөгжлийн төв, номын санд үе шаттай нэвтрүүлэх.	2 төхөөрөмж (программ бүхий)	3,162,500	6,325,000
			Нийт	38,000,000

оОо